

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХАНДЛАГА, ЁС ЗҮЙД ХИЙСЭН СУДАЛГАА

Т.Өсөхжаргал

ЭША, доктор, ахмад

Б.Батбаяр

Гамшиг судлалын төвийн дарга,
магистр, хошууч

Д.Балжинням

Галын инженер-судлаач, докторант,
ахмад

Хураангуй. Энэхүү сэдвийн хүрээнд онцгой байдлын байгууллагын залуу офицер, алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлагыг судалж, дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлыг авч үзсэн.

Түлхүүр үг: *Хандлага, ёс зүйн төлөвшил*

Оршил

Орчин үед мэдлэг, чадвартай хүний нөөцийн зэрэгцээ хүмүүнлэг харилцаатай, мэргэжлийн ёс зүйтэй байх асуудал ихээхэн чухлаар тавигдаж байна. Үүний илрэл болох Монгол Улсын төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх шинэ санал дэвшүүлж байгаа нь байгууллагын хүний нөөц бэлтгэх, улмаар нийгмийн харилцааг боловсронгуй болгох, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Аль ч салбарт мэргэжлийн ёс зүй бол тухайн мэргэжилтний болон улс орны хөгжилд чанарын шинэчлэл хийх үндсэн нөхцөл болдог.

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлд “төрийн улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасан байдаг ба ОБЕГ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/166 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тиймээс Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүйн төлөвшил, хандлагыг тодруулах зорилгоор санамсаргүй түүврийн аргаар асуумж судалгааг ёс зүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэн James Svava “Ёс зүй нь үүрэг, зарчим, тодорхой зан чанар, нийгэмд ашиг тустай байх хүрээнд хүний юуг хийх ёстойг заадаг зөв болон бурууг ялгах хэм хэмжээ” гэж тодорхойлсныг¹ тодруулах зорилго тавьсан. Энэхүү тодорхойлолтод ёс

¹ Дам., James Svava “The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations” Jones and Bartlett Learning LLC, 2015, page 12

зүйн эх сурвалжийн дөрвөн элементийг багтаасан бөгөөд нэг нь нийтийн албаны мөн чанартай холбоотой, гурав нь философийн агуулгатай. Үүнд²:

1. Үүрэг (duty): хүний эрхэлж буй ажил мэргэжил, албан тушаалтай холбогдон гарч ирэх ногдсон үүрэг хариуцлага, зан чанарын цогц.

2. Зан байдал, сайн чанар (virtue): “сайн хүн”-ийг тодорхойлох чанарууд.

3. Зарчим (principles): зан чанарын үндэс суурийг тодорхойлдог үнэн буюу зөв болон биелүүлэх ёстой үйлдлүүд.

4. Нийгэмд ашиг тустай байх (benefits to society): хамгийн олон хүнд хамгийн их сайныг авчрах үйлдэл гэж авч үзсэнд тулгуурлан дараах багц асуумжаар асуулга авсан.

ОББ-ын алба хаагчдын ёс зүйн төлөвшил, хандлага, сэтгэл зүйн байдлын судалгааг алба хаагчдын ёс зүйн хэмжээ, харилцаа, хандлага, сэтгэл ханамж гэсэн 10 багц буюу нийт 69 асуумжаар асуулга судалгаа авч дүгнэсэн.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ЁС ЗҮЙ, ХАНДЛАГА, СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ

Онцгой байдлын байгууллагын хандлага, ёс зүйн судалгаанд нийт 671 алба хаагчийг санамсаргүй түүврийн аргаар хамруулсан. Судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсрол, албан тушаал, ажилласан жил зэрэг ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Хүйс	Тоо, N	Эзлэх хувь
Эр	549	81,6 %
Эм	112	18,4 %
Нас		
18-25	178	26,1 %
26-32	253	37,1 %
33-39	175	25,7 %
40-47	62	9,1 %
48-55	13	1,9 %
56-аас дээш	0	0
Боловсрол		
Бүрэн дунд	289	42,4 %

²Дам. James Svava “The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations” Jones and Bartlett Learning LLC, 2015, page 12

Тусгай дунд /мэргэжлийн/	58	8,5 %
Дээд	295	43,3 %
Магистр ба түүнээс дээш	39	5,7 %
Албан тушаал		
Дээд шатны удирдлага	8	1,2 %
Дунд шатны удирдлага	127	18,6 %
Мэргэжилтэн	82	12 %
Аврагч, гал сөнөөгч, холбоочин	427	62,6 %
Энгийн ажилтан	38	5,6 %
ОББ-д ажилласан жил		
1-3	207	30,4 %
4-7	194	28,4 %
8-11	128	18,8 %
12-16	83	12,2 %
16-аас дээш	70	10,3 %

Судалгаанд оролцогчдын **82** хувь нь эрэгтэй, **18** хувь нь эмэгтэй, **90** орчим хувь нь **18-39** хүртэлх насны, дийлэнх нь бүрэн дунд олон дээд боловсролтой, ажилласан жил харилцан адилгүй, албан тушаалын хувьд дунд шатны удирдлага болон аврагч гал сөнөөгчид түлхүү хамрагдсан байна. Эндээс харахад судалгаанд оролцогчид нь байгууллагын алба хаагчдыг бүрэн төлөөлөх боломжтой гэж үзлээ.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүйн байдлыг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тандах хувь хүний үнэт зүйл, эр зориг, үнэнч байдал, шударга байдал, хариуцлага, ёс зүйтэй байдал гэсэн багц бүхий 30 асуумжаар, хандлага сэтгэл ханамжийн байдлыг манлайлал, удирдлага, Харилцаа холбоо, ажлын уялдаа, мэдээллийн солилцоо, Алба хаагчдын оролцооны түвшин, санал санаачлаг, Хувь хүний сэтгэл ханамж, Ажлын орчин нөхцөл, Цалин, урамшуулал, Хувь хүний хөгжил, Карьер өсөлт, Багийн ажиллагаа гэсэн багц 39 асуумжаар тус тус судалгаа авсан. Асуумж тус бүрийг 4 зэрэглэлд хувааж, 1-ээс 4 хүртэлх оноогоор үнэлүүлсэн.

Хүснэгт 2. Асуулга судалгааны дүн



Судалгааны үр дүнгээс харахад алба хаагчдын ёс зүй 3,5 буюу 87,5%, хандлага, сэтгэл ханамж 2,8 буюу 70%-ийн үзүүлэлттэй байна. Тухайлбал, ёс зүйн хувьд хувь хүний үнэт зүйл, түүнийгээ илэрхийлдэг байдал нь бусад үзүүлэлтээс харьцангуй өндөр хувийг эзэлж байгаа бол харилцаа холбоо, ажлын уялдаа холбоо, мэдээллийн хүртээмжтэй байдал, цалин хангамж, урамшууллын систем, удирдлага, манлайллын үзүүлэлт дундаас дээш хэдий ч бусад үзүүлэлттэй харьцуулахад доогуур буюу 2,6-2,7 (65-68%) гэж үнэлэгджээ.

69 асуумжийг тус бүрээр нь авч үзэн хамгийн өндөр үнэлгээ авсан 5, хамгийн доогуур үнэлгээ авсан 5 үзүүлэлтийг дор харуулав.

Хүснэгт 3. Ёс зүй, хандлага, сэтгэл ханамжийн судалгаагаар хамгийн өндөр үнэлгээ авсан 5 асуулт

Бүлэг	Бүлгийн нэр	Маш чухал	Чухал	Чухал биш	Огт чухал биш
		4	3	2	1
1	Би эх орондоо хайртай	553 82%	118 17.60%	0	0
2	Би үргэлж гэр бүлээ бодож, анхаарал тавьж байдаг	596 88.80%	75 11.20%	0	0
23	Би өөрийн хийсэн бүхнээ үнэнээр нь мэдээлж, тайлагнадаг	487 72.60%	167 24.90%	17 2.50%	0
25	Би үргэлж зөв зүйл хийхийг эрмэлздэг	522 77.80%	138 21%	11 16%	0

27	Би ёс зүйтэй байхыг үргэлж хичээдэг	529 78.80%	132 19.70%	10 15%	0
----	-------------------------------------	---------------	---------------	-----------	---

ОББ-ын алба хаагчдын 80-аас дээш хувь нь эх орон, гэр бүлээ маш чухал хэмээн эрхэмлэж, үнэнч, шударга, ёс зүйтэй байхыг 70-90 хувь нь эрмэлздэг гэж хариулсан байна.

Хүснэгт 4. Ёс зүй, хандлага, сэтгэл ханамжийн судалгаагаар доогуур үнэлгээ авсан 5 асуулт

Бүлэг	Бүлгийн нэр	Огт санал нийлэхгүй байна	Санал нийлэхгүй	Санал нийлнэ	Санал бүрэн нийлж байна
		1	2	3	4
30	Та нэг цэгийн үйлчилгээний төвд ажилладаг. Та төрсөн эгчдээ дараалал харгалзалгүй үйлчлүүлэх боломж олгоно	156	173	161	181
		23%	26%	24%	27%
33	Удирдлагын баг алба хаагчдынхаа нийгмийн болон бусад хангамжийн асуудалд ихээхэн анхаардаг	102	191	297	81
		15%	29%	44%	12%
37	Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар удирдлагын зүгээс нийт ажилтнуудыг мэдээллээр байнга хангадаг	102	193	301	75
		15.20%	28.80%	45%	11.20%
39	Удирдлагын багийн гишүүд алба хаагч бүртэй шударгаар харилцдаг	99	192	302	78
		14.80%	28.60%	45%	11.60%
55	Манай байгууллагын цалин хөлс ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай ижил түвшинд	123	206	279	63
		18.30%	30.70%	41.60%	9.40%

Асуулга судалгаагаар ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай ижил түвшний цалин авдаг гэсэн асуулгуудад 50 орчим хувь нь, нийт алба хаагчдыг санхүүгийн болон гүйцэтгэлийн үйл ажиллагааны мэдээллээр бүрэн хангадаг гэсэн асуулгад 43 хувь нь, удирдлагын багийн гишүүд алба хаагч бүртэй ижил тэнцүү, шударгаар харьцдаг, нийгмийн болон бусад хангамжийн асуудалд анхаардаг гэсэн асуулгад 42 хувь нь санал нийлэхгүй байна гэж тус тус хариулжээ.

Дүгнэлт

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүй, хандлагад хийсэн судалгаанаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Судалгааны үр дүнгээс харахад алба хаагчдын ёс зүй 3,5 буюу 87,5%, хандлага, сэтгэл ханамж 2,8 буюу 70%-ийн үзүүлэлттэй байна. Тухайлбал, ёс зүйн хувьд хувь хүний үнэт зүйл, түүнийгээ илэрхийлдэг байдал нь бусад үзүүлэлтээс харьцангуй өндөр хувийг эзэлж байгаа бол харилцаа холбоо, ажлын уялдаа холбоо, мэдээллийн хүртээмжтэй байдал, цалин хангамж, урамшууллын систем, удирдлага, манлайллын үзүүлэлт дундаас дээш хэдий ч бусад үзүүлэлттэй харьцуулахад доогуур буюу 2,6-2,7 (65-68%) гэж үнэлэгджээ.

-Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүйн байдал 87,5% үнэлэгдлээ. Энэ нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ болон хувь хүний үнэт зүйл, эр зориг, үнэнч байдал, шударга байдал, хариуцлага, ёс зүйтэй байхыг алба хаагчид эрмэлздэг болохыг харуулж байна.

- Асуулгаар ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай ижил түвшний цалин авдаг гэсэн асуулгуудад 50 орчим хувь нь, нийт алба хаагчдыг санхүүгийн болон гүйцэтгэлийн үйл ажиллагааны мэдээллээр бүрэн хангадаг гэсэн асуулгад 43 хувь нь, удирдлагын багийн гишүүд алба хаагч бүртэй ижил тэнцүү, шударгаар харьцдаг, нийгмийн болон бусад хангамжийн асуудалд анхаардаг гэсэн асуулгад 42 хувь нь санал нийлэхгүй байна гэж тус тус хариулсан байна.

Үр дүн ба хэлэлцүүлэг

-Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг хуулиар болон дүрэм журмаар нарийвчлан тодорхойлох, хариуцлага хяналтын тогтолцоог бий болгох, эрх зүйн баримт бичгийн уялдаа холбоо болон хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай. Тухайлбал, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүйн дүрэм, журмын нийцтэй байдал, төлөвлөлтөд тусч байгаа байдал, хэрэгжилтэд байнга хяналт тавьж, үр дүнг тусган тасралтгүй сайжруулалт хийдэг байх;

- Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журам"-ын хэрэгжилтийг хангах,

- Онцгой байдлын байгууллагын анги, салбар нэгжүүдийн болон дотоод харилцаа, хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадвар, ёс зүйгээр удирдлага манлайллыг бүрдүүлдэг байх;

- Авлига хээл хахуулиас ангид байхын тулд цалин хангамж, урамшууллын системийг бүх шатанд шилэн байх нөхцөлийг бүрдүүлэх;

- Дотоод хяналтын системээр хувь хүний ёс зүйн алдаа, системийн аливаа сул талыг илрүүлэх замаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах;

- Ёс зүй, хандлага, сэтгэл зүйн байдалд дүн шинжилгээ хийсэн суурь мэдээлэлд үндэслэн сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, уялдуулан зохицуулах шаардлагатай байна. Түүнчлэн онцгой байдлын албаны хэмжээнд хэрэгждэг хууль тогтоомжийг зөрчсөн асуудлыг бодитоор илрүүлэх, түүний үр дүнд уялдуулан төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх цогц сургалтын агуулга, хэлбэр, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, байнга сайжруулан, тогтмол явуулах. Өөрөөр хэлбэл сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр албаны сургалтыг зохион байгуулах.

Санал

Онцгой байдлын байгууллагын бүх салбар нэгжүүд нь 2019 оноос Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү стандартын хүрээнд **ТӨЛӨВЛӨ – ХИЙ – ХЯНА – САЙЖРУУЛ** гэсэн зарчмыг хэрэгжүүлэхдээ дээрх дутагдалтай асуудлуудыг тусган хэрэгжүүлснээр ёс зүй, хандлага, сэтгэл ханамж, сэтгэл зүйн байдал дээшилж улмаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах боломжтой юм.

Мөн Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг 2021 онд батлуулсан ба энэхүү хөтөлбөрийг байгууллагын бүх түвшинд хэрэгжүүлснээр алба хаагчдын хандлага, сэтгэл ханамж дээшилж, байгууллагын соёл төлөвших чухал ач холбогдолтой.